



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

**Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын  
хугацаа сунгах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн  
19 тоот тогтоолын  
хавсралт

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа  
сунгасан хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Олгосон дугаар	Хугацаа	Дугаарлалтын зориулалт
1	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1111	2024.10.01 2026.10.01	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ

----- оОо -----